# “АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ”
Хязгаарлагдмал хариуцлагатай компани

2014 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
**ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## Агуулга


| | Хуудасны № |
|---|---|
| **Байгууллагын талаарх мэдээлэл** | **2** |
| **Тусдаа Санхүүгийн тайланд хүлээх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл** | **3** |
| **Хараат Бус Аудиторын тайлан** | **4-5** |
| **Тусдаа Санхүүгийн Тайлангууд** | **6-9** |
| Тусдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан | 6 |
| Тусдаа Санхүүгийн Байдлын Тайлан | 7 |
| Тусдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан | 8 |
| Тусдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан | 9 |
| **Тусдаа санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд** | **10-59** |
| Тайлагнагч аж ахуй нэгж | 10 |
| Тайлан бэлтгэсэн үндэслэл | 10-11 |
| Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандарт, тайлбар ба нэмэлт өөрчлөлтүүд | 11-16 |
| Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл | 17 |
| Санхүүгийн хэрэгслүүд –Эрсдэлийн Удирдлага | 18-27 |
| Санхүүгийн тайлангийн тодруулгууд | 28-46 |
| Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй | 47-56 |
| Холбоотой талын тодруулга | 57-58 |
| Санхүүгийн Тайлангийн нэмэлт тодруулгууд | 59 |

# БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **Үүсгэн байгуулах шийдвэр** | Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2005 оны 10 сарын 10-ны өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу И Ай Ти ХХК нэртэйгээр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.<br>2014 оны 04 сарын 08-ний өдрийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу И Ай Ти ХХК-ийн нэрийг Ард Санхүүгийн Нэгдэл болгон өөрчилсөн бөгөөд 2014 оны 06 сарын 26-ны өдрөөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн. |
| **Гэрчилгээ ба тусгай зөвшөөрөл** | Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2005 оны 10 сарын 18-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж Улсын Бүртгэлийн 9011036140 тоот дугаар бүхий, 5024145 тоот регистрийн дугаартай гэрчилгээг авсан. |
| **Гол хувь нийлүүлэгчид** | Интер Групп Интернэйшнл ХХК 13.32%<br>Юу Би Ай Жи ХХК 11.35%<br>Аполло Винтурс ХХК 10.06%<br>Ventures One BV 7.76 %<br>Ч.Ганхуяг 7.68%<br>Луна энд Луна ХХК 7.65%<br>МАК ХХК 5.2%<br>Бусад 36.98% |
| **Төлөөлөн Удирдах Зөвлөл** | Ж.Оюунгэрэл, ТУЗ-ийн дарга<br>Ч.Ганхуяг, ТУЗ-н гишүүн<br>П.Батбаяр, ТУЗ-н гишүүн<br>Н.Цэлмүүн, ТУЗ-ийн гишүүн<br>Л.Соронзонболд,ТУЗ-ийн гишүүн<br>Б.Нэмэхбаатар,ТУЗ-ийн гишүүн<br>Б.Ганбат,ТУЗ-ийн гишүүн<br>А.Батболд ,ТУЗ-ийн гишүүн<br>Б.Болормаа, ТУЗ-н гишүүн<br>С.Гэрэлтуяа ,ТУЗ-ийн гишүүн<br>Л.Жавзмаа, ТУЗ-ийн гишүүн<br>М.Сэргэлэн, ТУЗ-ийн гишүүн<br>Г.Цогбадрах, ТУЗ-ийн гишүүн<br>Энтони Хобров, ТУЗ-н гишүүн |
| **Гүйцэтгэх Удирдлага** | Ч.Ганхуяг, Гүйцэтгэх захирал |
| **Байнгын хаяг** | **Ард Санхүүгийн Нэгдэл ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар хот,<br>Сүхбаатар дүүрэг , 8-р хороо,<br>Бага тойруу 14200, Б.Алтангэрэлийн гудамж,<br>Сити центр барилга-403 тоот |
| **Аудитор** | **БДО Аудит ХХК**<br>Монгол Улс, Улаанбаатар,<br>Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол,<br>6-р хороо, Их сургуулийн гудамж 32/1,<br>АБ Центр, 10-р давхар |

**2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**
**Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаар**
**Удирдлагын Хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тусдаа тайлангийн хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн (цаашид "Компани") 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн тусдаа санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, МУ-н нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд санхүүгийн тайлангууд нь 2014 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлнэ.

Тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Удирдлага нь:

- Нягтлан бодох бүртгэлийн тохирох зарчмуудыг сонгож, тууштай хэрэгжүүлэх;
- Ул үндэстэй бөгөөд оновчтой шийдэл болон тооцоолол хийх;
- СТОУС-ыг даган мөрдсөн эсэх болон СТОУС-аас зөрүүтэй байгаа зүйлсийн талаар нэмэлт тодруулга, тайлбар хийсэн эсэх талаар дурдах;
- Компани нь ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлэх эсэхийг төсөөлөхөд тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг өөдрөг төсөөллийн сууриар бэлтгэх үүргийг хүлээдэг.

Мөн удирдлага нь дараах үүргийг хүлээнэ:

- Компанийн хэмжээнд дотоод хяналтын системийг үр дүнтэй, тохирохуйц зохион байгуулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;
- Компанийн санхүүгийн байдлыг ул үндэстэй үнэнээр илэрхийлэхүйц мөн Компанийн тусдаа санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу бэлтгэгдэх боломжоор хангасан нягтлан бодох бүртгэл хөтлөх;
- Монгол улсын Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар журам, холбогдох Монгол улсын хуулийг даган мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;
- Компанийн хөрөнгийг хамгаалахтай холбоотой зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх; болон
- Заль мэх болон бусад зөрчлүүдийг илрүүлэх буюу тэдгээрээс урьдчилан сэргийлэх.

Компанийн удирдлагын хувьд 2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн тусдаа санхүүгийн тайлангуудыг гаргахыг 2015 оны 05 сарын 20 -ний өдөр батлав.

____________________________ ____________________________

| **Ч. Ганхуяг** | **Т. Батцэнгэл** |
|---|---|
| *Гүйцэтгэх захирал* | *Нягтлан бодогч* |

Огноо: ________________________

Улаанбаатар хот, Монгол Улс

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХХК -ийн 5-58 дугаар хуудсанд тусгагдсан 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Тусдаа Санхүүгийн Байдлын Тайлан, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн Тусдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан, Тусдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, Тусдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

***Тусдаа санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага***

Удирдлага нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг НББОУС 27, *Тусдаа санхүүгийн тайлан* -ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Үүнд тусдаа санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг зохион байгуулж ажиллуулан, хэвийн түвшинд сахих; тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх; нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

***Аудиторын үүрэг хариуцлага***

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь тусдаа санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед тусдаа санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн тусдаа санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

***Аудиторын дүгнэлт***

Бидний дүгнэлтээр, тусдаа санхүүгийн тайлангууд нь Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан* (“НББОУС 27”)-ын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

***Тайлангийн хэрэглээ***

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

______________________________

**БДО Аудит ХХК**
Улаанбаатар хот,Монгол Улс
**Тусгай зөвшөөрөл: 009-1997**

Огноо: ________________

# АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
**ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

| | Тэм | 2014 мян.төг | 2013 мян.төг |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 5 | 6,801,686 | 627,600 |
| Хөрөнгө оруулалтын дансны үнэ | 6 | (1,122,042) | - |
| **Нийт ашиг/(алдагдал)** | | **5,679,644** | **627,600** |
| Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн хэрэгжсэн олз | | (6,545,956) | - |
| Ерөнхий удирдлагын зардал | 7 | (1,453,532) | (157,628) |
| Ажилчидтай холбоотой зардал | 8 | (390,231) | (230,013) |
| Үйл ажиллагааны бус орлого | 9 | - | 19,238 |
| **Үйл ажиллагаанаас олсон ашиг/(алдагдал)** | | **(2,710,075)** | **259,197** |
| ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн өсөлтийн олз | | 415,584 | - |
| Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээний олз | | (91,483) | 14,520,275 |
| Цэвэр санхүүгийн зардал | 10 | 177,365 | (426,583) |
| **Татварын өмнөх ашиг/(алдагдал)** | | **(2,208,609)** | **14,352,889** |
| Орлогын албан татварын зардал | 11 | (518,144) | (8,127) |
| Хойшлогдсон татварын орлого (зардал) | 11 | 975,939 | (4,077,963) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)** | | **(1,750,815)** | **10,266,799** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| ***Ашиг алдагдлаар дахин ангилал хийгдэхгүй зүйлс:*** | | | |
| Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өсөлт | | 933,684 | 1,791,577 |
| **Нийт дэлгэрэнгүй ашиг /(алдагдал)** | | **(817,131)** | **12,058,376** |

*10-59-р хуудсанд хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

# АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
## Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
## 2014 оны 12 сарын 31-ний өдрөөрх
# ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Тэм | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж | 12 | 189,414 | 348,472 | 358,606 |
| ХОЗҮХХ | 13 | 675,148 | - | - |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө оруулалт | 14 | 32,024,057 | 31,499,654 | 15,647,429 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **32,888,619** | **31,848,126** | **16,006,035** |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | | |
| Бараа материал | | 1,301 | 16 | 3,010 |
| Урьдчилж төлсөн тооцоо, зардал | 17 | 100,876 | 306,738 | 155,884 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 18 | 177,820 | - | - |
| Охин компани болон хараат компанид олгосон зээл | 15 | 521,878 | 535,948 | 244,234 |
| Зээлийн авлага | 16 | 207,267 | 586,200 | 556,989 |
| Худалдааны ба бусад авлага | 19 | 168,543 | 116,010 | 462,626 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 20 | 408,470 | 182,868 | 209,802 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **1,586,155** | **1,727,780** | **1,632,545** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **34,474,774** | **33,575,906** | **17,638,580** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | | | |
| **Өмч** | | | | |
| Хувьцаат капитал | 21 | 1,833,551 | 1,703,147 | 1,703,147 |
| Халаасны хувьцаа | 21 | (154,018) | (326,929) | (260,748) |
| Нэмж төлөгдсөн капитал | 22 | 9,298,761 | 3,246,555 | 3,303,839 |
| Хуримтлагдсан ашиг | | 10,969,818 | 13,128,835 | 3,053,675 |
| Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц | 23 | 6,225,670 | 5,291,986 | 3,500,408 |
| Өмчийн бусад хэрэглүүр | 24 | 13,799 | 13,799 | 13,799 |
| **Нийт өмч** | | **28,187,581** | **23,057,393** | **11,314,120** |
| **Өр төлбөр** | | | | |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | | |
| Урт хугацаат зээл | 25 | - | 210,999 | 3,626,976 |
| Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг | 26 | - | 199 | 12,594 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 28 | 4,671,006 | 5,646,944 | 1,568,981 |
| **Нийт урт хугацаат зээл** | | **4,671,006** | **5,858,142** | **5,208,551** |
| **Эргэлтийн өр төлбөр** | | | | |
| Худалдааны ба бусад өр төлбөр | 27 | 790,940 | 2,449,893 | 967,007 |
| Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг | 25 | 210,999 | 2,042,055 | |
| Урт хугацаат санхүүгийн түрээсийн богино хугацаанд төлөгдөх хэсэг | 26 | - | 24,793 | 12,396 |
| Орлогын албан татварын өглөг | | 478,069 | 7,452 | 65 |
| Бусад эргэлтийн өр төлбөр | | 136,179 | 136,178 | 136,441 |
| **Нийт эргэлтийн өр төлбөр** | | **1,616,187** | **4,660,371** | **1,115,909** |
| **Нийт өр төлбөр** | | **6,287,193** | **10,518,513** | **6,324,460** |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **34,474,774** | **33,575,906** | **17,638,580** |

*10-59-р хуудсанд хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ**
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
**ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

| | Хувьцаат капитал | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц | Хуримтлагд сан ашиг | Өмчийн бусад хэрэглүүр | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг | мян.төг |
| | (Тэм 21) | (Тэм 21) | (Тэм 22) | (Тэм 23) | | (Тэм 24) | |
| **2013 оны 1 сарын 1-ээр** | **1,703,147** | **(260,748)** | **3,303,839** | **-** | **6,554,083** | **13,799** | **11,314,120** |
| Бодит үнэ цэнийн тохируулга | - | - | - | 3,500,408 | (3,500,408) | - | - |
| **2013 оны 1 сарын 1-ээр залруулагдсан үлдэгдэл** | **1,703,147** | **(260,748)** | **3,303,839** | **3,500,408** | **3,053,675** | **13,799** | **11,314,120** |
| Хувьцаа халаасалсан | - | (77,069) | (155,107) | | (191,639) | - | (423,815) |
| Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа | - | 10,888 | 97,823 | | - | - | 108,711 |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | | 10,266,799 | - | 10,266,799 |
| Бодит үнэ цэнийн өсөлт | | | | 1,791,578 | | | 1,791,578 |
| **2013 оны 12 сарын 31** | **1,703,147** | **(326,929)** | **3,246,555** | **5,291,986** | **13,128,835** | **13,799** | **23,057,393** |
| Хувьцаа халаасалсан | - | (57,397) | (114,634) | | (408,202) | - | (580,233) |
| Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа | 130,404 | 230,308 | 6,166,840 | | - | - | 6,527,552 |
| Тайлант жилийн алдагдал | - | - | - | | (1,750,815) | - | (1,750,815) |
| Бодит үнэ цэнийн өсөлт | | | | 933,684 | | | 933,684 |
| **2014 оны 12 сарын 31** | **1,833,551** | **(154,018)** | **9,298,761** | **6,225,670** | **10,969,818** | **13,799** | **28,187,581** |

*10-59-р хуудсанд хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

# АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
**ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

| | 2014<br>мян.төг | 2013<br>мян.төг |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:** | | |
| **Татварын өмнөх ашиг/(алдагдал)** | **(2,208,609)** | **14,352,889** |
| *Тохируулга:* | | |
| Элэгдэл болон хорогдуулга | 40,125 | 11,467 |
| Хүүгийн орлого | (98,193) | (45,529) |
| Хүүгийн зардал | 52,756 | 226,292 |
| Гадаад валютын арилжаанаас орсон олз | - | (4,952) |
| Гадаад валютын ханшийн зөрүү | (92,413) | 77,035 |
| Найдваргүй авлагын нөөцийн зардал | 470,374 | - |
| Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээ | (323,687) | (14,520,274) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ ба хэрэгжсэн борлуулалтын үнийн зөрүү | 1,017,873 | - |
| **Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг** | **(1,141,774)** | **96,928** |
| ***Ажлын капиталын өөрчлөлт:*** | | |
| Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө | - | 149,475 |
| Бусад хөрөнгө | (148,215) | 498,756 |
| Бусад өр төлбөр | (2,048,575) | 1,491,928 |
| **Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгө** | **(3,338,564)** | **2,237,087** |
| Хүлээн авсан хүү | 229,782 | 25,753 |
| Төлсөн хүү | (52,756) | (235,596) |
| Төлсөн орлогын албан татвар | (47,527) | (739) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **3,209,065** | **2,026,504** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:** | | |
| Худалдан авсан үндсэн хөрөнгө | (180,591) | (1,333) |
| Худалдсан үндсэн хөрөнгө | 39,960 | |
| Худалдан авсан өмчийн хөрөнгө оруулалт | (713,000) | (300,000) |
| Худалдан авсан түргэн борлогдох үнэт цаас | (27,820) | - |
| Худалдаж авсан бонд | (150,000) | - |
| Худалдсан хөрөнгө оруулалт | 6,650,124 | - |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ** | **5,618,673** | **(301,333)** |
| **САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:** | | |
| Охин компанид олгосон зээл | (431,337) | (532,526) |
| Охин компанид олгосон зээлийн эргэн төлөлт | 314,377 | 296,117 |
| Авсан зээлийн эргэн төлөлт | (2,067,046) | (1,515,697) |
| **Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(2,184,006)** | **(1,752,104)** |
| **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **225,602** | **(26,934)** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **182,868** | **209,802** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **408,470** | **182,868** |

*10-59-р хуудсанд хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

## 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙ НЭГЖ

Ард Санхүүгийн Нэгдэл ХХК ("Компани") нь 2005 оны 10 сарын 10-ны өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу И Ай Ти Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2005 оны 10 сарын 18-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж Улсын Бүртгэлийн 9011036140 тоот дугаар бүхий, 5024145 тоот регистрийн дугаартай гэрчилгээг авсан.

2014 оны 04 сарын 08-ний өдрийн ТУЗ-н шийдвэрийн дагуу И Ай Ти ХХК-ийн нэрийг Ард Санхүүгийн Нэгдэл болгон өөрчилсөн бөгөөд 2014 оны 06 сарын 26-ны өдрөөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь бизнесийн зөвлөгөө өгөх ба хөрөнгө оруулалт бөгөөд компани нь тэмдэглэл 14-д дурдсан компаниудад хөрөнгө оруулсан бөгөөд хөрөнгө оруулалттай компаниудын үндсэн үйл ажиллагааг эдгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэл 14-д дэлгэрэнгүй тайлбарласан.

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр тусдаа тайлангууд нь Компанийн НББОУС 27, "Тусдаа санхүүгийн тайлан"–ийн дагуу бэлтгэгдсэн тусдаа санхүүгийн тайлан болно. Компани Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу тусдаа санхүүгийн тайланг бэлтгэсэн бөгөөд охин болон хараат, хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжиж тайлагнасан. Энэхүү тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхэд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын тухай мэдээллийг 33 дугаар тэмдэглэлд оруулсан. Холбогдох хэсэгт тусгайлан зааснаас бусад тохиолдолд тэмдэглэл 33-д заасан бодлогуудыг хэрэглэсээр ирсэн.

Компанийн үйл ажиллагааны болон тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг болно. Эдгээр тусдаа санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

Эдгээр тусдаа санхүүгийн тайлангууд нь дор дурдсан СТОУС, НББОУС-аас бусад зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо ("НББОУСХ")-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн. Үүнд:

- СТОУС 10, Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд;
- СТОУС 11, Хамтын хэлцэл,
- СТОУС 12, Бусад аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын нэмэлт тодруулга.

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг.

*Хэмжилтийн Үндэслэл*

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх;
- Тодорхойлсон тэтгэмжийн цэвэр өр төлбөр.

### Өөдрөг төсөөлөл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь өөдрөг төсөөлөлд суурилан бэлтгэгдсэн.

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт**

*a) Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжээс Хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнээр хэмжсэн Толгой компанид шилжих үеийн бодлогын өөрчлөлт*

Компанийн удирдлага нь 2013 оны 12-р сарын 31-нийг хүртэл хугацаанд компанийг Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж гэж тодорхойлж, охин компанид оруулсан бүх хөрөнгө оруулалтыг СТОУС 9, *Санхүүгийн хэрэглүүр* -д заасан ашиг, алдагдлаар хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Компанийн удирдлага нь 2014 оны 12 сарын 31-нээр компанийг Толгой компани хэмээн үнэлж, зөвхөн толгой компанийн Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд Хөрөнгө оруулалтаа НББОУС 27 “Тусдаа санхүүгийн тайлан”-ийн 10(b)-д болон СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнээр нь хэмжиж, бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Энэхүү бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн буцаах горимыг хэрэглэн тайлагнасан.

Энэхүү санхүүгийн тайлан нь СТОУС 10 “Нэгтгэсэн санхүүгийн тайлан”-ийн дагуу бэлтгэгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан биш болно.

*b) 2014 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх шинэ стандартууд, тайлбарууд болон өөрчлөлтүүд*

2014 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн анх удаа хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх нэг шинэ стандарт болон хэд хэдэн өөрчлөлтүүдийг эдгээр санхүүгийн тайлангуудад хэрэглэсэн. Компанийн хэрэгжүүлсэн шинэ тайлбар болон өөрчлөлт бүрийн шинж чанар ба нөлөөг доор тайлбарлалаа.

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| *НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга* | *Санхүүгийн Хөрөнгө ба Санхүүгийн Өр Төлбөрийг Цэвэрлэх нь*<br>Энэхүү өөрчлөлтөөр санхүүгийн хэрэглүүрийг цэвэрлэхтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тодотгосон. НББОУС 32.AG38B гэсэн шинэ заалтаар цэвэр дүн гаргах эрхийг дараах байдлаар тодорхойлсон:<br>a) Ирээдүйн үйл явдлаас болзошгүй байх ёсгүй; ба (Ирээдүйд болзошгүй үүрэг хариуцлага үүсэх ёсгүй)<br>b) Дараах бүх тохиолдолд хуулиар хэрэгжихүйц байх шаардлагатай<br>i) Бизнесийн хэвийн үйл ажиллагаа;<br>ii) Гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэх чадваргүй болох; ба<br>iii) Аж ахуйн нэгж ба түүний бүх бизнесийн түншүүд төлбөрийн чадваргүй болох эсвэл дампуурах.<br>Энэхүү өөрчлөлтүүд нь НББОУС3-ийн цэвэр дүнг гаргах төслийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн нэг хэсэгт, НББОУС3-өөс “*Санхүүгийн Хөрөнгө ба Санхүүгийн Өр Төлбөрийн Цэвэр дүнг гаргах”*-ыг гаргасан ба энэ нь 2013 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх юм (СТОУС 7-д орсон өөрчлөлт).<br>2014 оны 01 сарын 01-ний өдөр ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)**

*b) 2014 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх шинэ стандартууд, тайлбарууд болон өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| *СТОУТХ 21, Татвар шимтгэл* | СТОУТХ 21-ээр дараах нөхцөлүүдийг хангасан зүйлсэд засгийн газрын татвар ногдуулсантай холбоотой өр төлбөрийг хэрхэн хүлээн зөвшөөрөх тухай удирдамжаар хангадаг:<br>- НББОУС 37 “Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө”-ийн дагуу бүртгэгдсэн;<br>- Хугацаа болон үнийн дүн нь тодорхой.<br>СТОУТХ 21-ийн дагуу татвар шимтгэл төлөх өр төлбөр үүсгэдэг үүрэг хүлээсэн үйл явдал гэдэг нь хууль зохицуулалтаар заасан татвар шимтгэлийг төлөхөд хүргэдэг үйл ажиллагаа юм гэсэн байдаг. Дараах хүчин зүйлс нь үүрэг хүлээсэн үйл явдлыг үүсгэх эсвэл илэрхийлдэггүй байна:<br>- Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын дагуу санхүүгийн тайлан бэлтгэх<br>Аж ахуйн нэгжийн эдийн засгийн хавчлага.<br>Үүрэг хүлээсэн үйл явдал үргэлжилсээр байх үед татвар шимтгэлийн өр хүлээн зөвшөөрөлт үргэлжилсээр байна. Хэрэв өр төлбөр нь хамгийн бага босго дүнгээр хамаардаг бол тухайн хамгийн бага босго дүнг давсан үед татвар шимтгэлийг хүлээн зөвшөөрөх бөгөөд харин түүнээс өмнө зөвшөөрөхгүй.<br>2014 оны 01 сарын 01-ний өдөр ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |
| СТОУС 11, *Хамтарсан Хэлцэл* -д орсон өөрчлөлт 2014 оны 5 сард гаргасан | *СТОУС 11-д орсон өөрчлөлт – Хамтарсан Үйл Ажиллагаан* Дахь Хувь Оролцооны Худалдан Авалтын Бүртгэл<br>Энэ өөрчлөлтийн аж ахуйн нэгж СТОУС 3-аар тодорхойлсон бизнесээс бүрдэх хамтарсан үйл ажиллагаанд хувь оролцоо худалдан авсан тохиолдолд СТОУС 3 Бизнесийн Нэгдлийн бүх зарчмуудыг хэрэглэхийг шаарддаг.<br>2016 оны 1 сарын 1 ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |
| НББОУС 36 Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт—орсон өөрчлөлт | *Тодруулга – хөрөнгийн (эсвэл мөнгө бий болгогч нэгжийн) эргэн нөхөгдөх дүн*<br>НББОУС 16.134 (c)-ын дагуу хөрөнгийн (эсвэл мөнгө бий болгогч нэгжийн) эргэн нөхөгдөх дүнг тайлант жилд тухайн хөрөнгөтэй холбоотой (мөнгө бий болгогч нэгж) үнэ цэнийн бууралт бүртгэсэн эсвэл буцаах бичилт хийсэн эсэхээс үл хамааран тодруулахыг шаарддаг (дансны үнэ нь нөлөө бүхий бол). | Материаллаг нөлөөгүй |
| НББОУС 27, Тусдаа Санхүүгийн Тайлан-д орсон өөрчлөлт 2014 оны 12 сард гарсан | *Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга*<br>Стандартын өөрчлөлтөөр аж ахуйн нэгж нь охин компани, хараат компани мөн хамтарсан үйлдвэрийн газарт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн арга ашиглан тусдаа санхүүгийн тайланд бүртгэх сонголтын талаар тусган харуулсан. Тайландаа СТОУС-г ашигладаг аж ахуй нэгж нь тусдаа санхүүгийн тайландаа өмчийн арга ашиглахаар сонгосон бол тэдгээрт буцаах горим мөрдөнө. Хэрвээ СТОУС-г анх удаа хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж тэдгээрийн тусдаа санхүүгийн тайланд өмчийн аргыг СТОУС-рүү шилжих өдрөөс эхлэн мөрдөнө.<br>2016 оны 01 сарын 01 ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)**

*b) 2014 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх шинэ стандартууд, тайлбарууд болон өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| *СТОУС 7, Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга* | Үйлчилгээ үзүүлэх гэрээ болон цэвэрлэх өөрчлөлтүүдийн хураангуй хагас жилийн санхүүгийн тайланд хэрэглэгдэх байдал<br>*Үйлчилгээ үзүүлэх гэрээ*<br>Аж ахуйн нэгж шилжүүлсэн хөрөнгийн үйлчилгээнээс байнгын оролцоотой байх тохиолдлуудыг НББОУС3-өөс тодруулсан. Шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн гүйцэтгэлд үйлчилгээ үзүүлэгч ирээдүйн ашиг сонирхолтой байх тохиолдолд байнгын оролцоо оршин байна.<br>Хагас жилийн хураангуйлсан санхүүгийн тайланд багтсан цэвэрлэх өөрчлөлтүүдийн тохиромжтой байдал<br>2011 оны 12 сард гаргасан Санхүүгийн Хөрөнгө ба Санхүүгийн Өр Төлбөрийг Цэвэрлэх (СТОУС 7-д орсон өөрчлөлт) өөрчлөлтийн хэрэглээг бүх хагас жилээр шаардахгүй гэсэн өөрчлөлтийг СТОУС 7-д орсон өөрчлөлт тодруулсан.<br>Харин зарим тохиолдолд эдгээр тодруулгыг НББОУС 34-ийг даган мөрдөхийн тулд хагас жилийн хураангуйлсан санхүүгийн тайланд багтаах шаардлагатай тулгарч болно.<br>2016 оны 1 сарын 1-ний өдөр ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ | Материаллаг нөлөөгүй |
| *СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр*<br><br>*2014 оны 7 сард гаргасан* | НББОУС 39 *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилтийн* хамрах хүрээнд багтаж буй бүх хөрөнгөд СТОУС 9 (2009)-ийг ашиглана. СТОУС 9-ийн дагуу анхны хүлээн зөвшөөрөлтийн үеэр бүх санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжиж (бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжигдээгүй тохиолдолд тодорхой ажил гүйлгээний өртгийн тохируулгыг нэмнэ), дараа үеийн хэмжилтийн дараах ангиллын аль нэгээр нь ангилна:<br>- Хорогдуулсан өртөг<br>- Бодит үнэ цэнэ.<br>СТОУС 9 (2009)-өөр Дуусах Хугацаа Хүртэл нь Эзэмшсэн, Борлуулахад Бэлэн, Зээл ба Авлага гэсэн ангиллуудыг устгасан. Үүнээс гадна, өмчийн хэрэглүүр ба холбогдох үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй байх тохиолдолд бодит үнэ цэнээр нь бус өртгөөр нь хэмжинэ гэсэн заалтыг устгаж эдгээр бүх хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь хэмжихээр тусгасан.<br>Аж ахуйн нэгжийн анхны хэрэглээ нь 2015 оны 2 сараас өмнөх байх тохиолдолд хэрэглэнэ. | Материаллаг нөлөөтэй |

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)**

*b) 2014 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх шинэ стандартууд, тайлбарууд болон өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| *СТОУС 9 (2014) , Санхүүгийн хэрэглүүр* | СТОУС 9 *Санхүүгийн Хэрэглүүр* (2014) нь санхүүгийн хэрэглүүрийн төслийн гурван үе шат болох ангилал ба хэмжилт, үнэ цэнийн бууралт болон хейджийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг эцсийн байдлаар бүгдийг нь хамарсан.<br>СТОУС 9 (2014) нь хуучин СТОУС 9-д дараах зүйлсийг нэмсэн:<br>- Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдээгүй бүх санхүүгийн хөрөнгүүдэд зориулсан үнэ цэнийн бууралтын шинэ шаардлагууд<br>- Санхүүгийн хөрөнгийн өмнө нь эцэслэсэн ангилал ба хэмжилтийн шаардлагуудад орсон өөрчлөлт.<br>СТОУС 9 (2014)-ийн 'таамагласан алдагдал' үнэ цэнийн бууралтын шинэ загвар нь НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилтийн 'гарсан алдагдал'-ыг солих бөгөөд энэ нь бүх аж ахуйн нэгжүүдэд нөлөөлөх гол өөрчлөлт юм.<br>СТОУС 9 (2014)-ийн дагуу үнэ цэнийн бууралтын загвар нь тухайн зээлийн үйл явдлын хувьд (эсвэл үнийн цэнийн бууралтын 'үйл явдал') илүү 'ирээдүйг харсан' загвар бөгөөд зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхийн өмнө үүссэн байх шаардлагагүй болж байгаа юм.<br>2018 оны 01 сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойш заавал хэрэглэнэ. | Материаллаг нөлөөтэй |
| *СТОУС 9, (өөрийн зээлийн эрсдэлийн шаардлагууд) Санхүүгийн хэрэглүүр* | СТОУС 9-ийн бусад шаардлагуудыг дагалгүйгээр бодит үнэ цэнийн опцион дох бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн 'өөрийн зээлийн' нөөцийг хэрэглэх сонголтыг СТОУС 9 (2014) олгосон. Энэ сонголт 2018 оны 01 сарын 01 хүртэл хүчинтэй байна.<br>Бодит үнэ цэнийн опцион хэрэглэдэг бөгөөд бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд тусгахын оронд бусад дэлгэрэнгүй орлогын 'өөрийн зээл'-д тусгадаг аж ахуйн нэгжүүд.<br>Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн байгууллага ба даатгалын байгууллагад голчлон нөлөөлнө гэж үзэж байна.<br>СТОУС 9 (2014)-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх огноо болох 2018 оны 01 сарын 01 хүртэл хэрэглэж болно. | Материаллаг нөлөөгүй |
| *СТОУС 13, Бодит үнэ цэнийн хэмжилт* | *Богино-хугацаат авлага ба өглөг*<br>Хэрвээ дискаунтын нөлөө нь материаллаг бус байвал тогтоосон хүүгийн түвшингүй богино-хугацаат авлага болон өглөгийг дикаунтчилаагүй нэхэмжлэхийн дүнгээр хэмжихийг стандартын өөрчлөлт тодруулсан.<br>Стандарт нь 2014 оны 07 сарын 01 ба түүнээс хойших хугацаанд заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөтэй |

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

### Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)

*b) 2014 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх шинэ стандартууд, тайлбарууд болон өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| СТОУС 15 *Харилцагчидтай Хийсэн Гэрээнээс Олсон Орлого*<br><br>2014 оны 5 сард гаргасан | СТОУС 15 Харилцагчидтай Хийсэн Гэрээнээс Олсон Орлого нь НББОУС 18 Орлого, НББОУС 11 Барилгын Гэрээ болон холбогдох Тайлбарууд (СТОУТХ 13 Харилцагчийн Үнэнч Байдлын Хөтөлбөр, СТОУТХ 15 Үл Хөдлөх Хөрөнгө Барих Гэрээ СТОУТХ 18 Харилцагчаас Хөрөнгө Шилжүүлэх нь, СТХ 31 Орлого – Зар Сурталчилгааны Үйлчилгээ бүхий Бартерын Гүйлгээ)-ийг орлоно.<br>СТОУС 15-ын гол зорилго нь орлого хүлээн зөвшөөрөлтийн зарчмыг тодорхой болгох явдал юм. Үүнд тогтворгүй байдал болон сул талыг арилгаж, компани, салбар болон капиталын зах зээл хоорондын орлого хүлээн зөвшөөрөлтийн практикийн зэрэгцүүлэх байдлыг сайжруулах явдал юм. Ингэснээр СТОУС 15 нь орлого хүлээн зөвшөөрөх ганц үзэл баримтлалыг тогтоож өгөх юм. Үзэл баримтлалын гол зарчим нь аж ахуйн нэгж харилцагчид амласан бараа эсвэл үйлчилгээг шилжүүлэхдээ тухайн бараа үйлчилгээнээс авах төлбөрөө илэрхийлсэн дүнгээр орлогоо хүлээн зөвшөөрөх явдал юм.<br>2017 оны 01 сарын 01 ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөтэй |
| НББОУС 16, *Өмч, Барилга, Тоног Төхөөрөмж-д орсон өөрчлөлт* | *Дахин үнэлгээний арга – хуримтлагдсан элэгдлийн хувь тэнцүүлсэн дахин илэрхийлэл*<br>Өмч, барилга, тоног төхөөрөмжийг дараа үеүдэд дахин үнэлгээний арга хэрэглэн хэмжсэн үед хуримтлагдсан элэгдлийн тооцооллыг энэ өөрчлөлтөөр тодорхойлсон.<br>2014 оны 7 сарын 1 ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ.<br>*НББОУС 16 ба НББОУС 38-д орсон өөрчлөлтүүд – Элэгдэл ба Хорогдол Тооцох Хүлээн Зөвшөөрөдөх Аргын Тодорхойлолт*<br>Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл тооцоход орлогод суурилсан арга хэрэглэхийг 62А дугаар зүйлээр хориглосон.<br>Элэгдлийн дүн ба элэгдүүлэх үед удирдамжаар хангасан 56 дугаар зүйлийн дагуу өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийн үйлдвэрлэсэн зүйлсийн борлуулах үнэ ирээдүйд буурахаар таамаглаж байгаа бол энэ нь техникийн эсвэл арилжааны хуучралыг илэрхийлж байж болох ёс гэсэн (тиймээс зүйлсэд шингэсэн эдийн засгийн өгөөжийн бууралт) элэгдүүлэх дүн эсвэл зүйлийн хугацаанд орсон өөрчлөлтөөс илүүтэйгээр.<br>2016 оны 01 сарын 01 ба түүнээс хойш заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |

## 2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт (үргэлжлэл)**

c) *Хараахан хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээгүй байгаа шинэ стандартууд, тайлбарууд ба өөрчлөлтүүд*

| Шинэ ба өөрчлөлт орсон СТОУС, тайлбарууд | Шаардлагуудын хураангуй | Санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөлөл |
|---|---|---|
| НББОУС 19, *Ажилчдын тэтгэмж* | *НББОУС 19-д орсон өөрчлөлтүүд – Тогтоосон Тэтгэмжийн Төлөвлөгөө: Ажилчдын Нөхөн Олговор*<br>Энэ өөрчлөлт нь дараах зүйлсийг агуулсан бага хүрээтэй хамрах хүрээг танилцуулсан:<br>- Ажиллагсад эсвэл гуравдагч этгээдийн тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөөнд оруулсан тодорхой хувь нэмрийг практикийн арга барилаар хангана. Гэхдээ зөвхөн ажилласан жилийн тооноос хараат бус нөхөн олговор л багтана<br>- Практикийн арга барилыг хамрах шаардлагагүй тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөөнд ажиллагсад эсвэл гуравдагч этгээдийн оруулсан хувь нэмрийг хэрхэн бүртгэх тухай. Үүнийг НББОУС 19.70-ын дагуу нийт тэтгэмжтэй ижил аргаар бүртгэнэ.<br>Стандарт нь 2014 оны 07 сарын 01 ба түүнээс хойших хугацаанд заавал хэрэгжүүлнэ.<br><br>*Хөнгөлөлтийн хувь – бүс нутгийн зах зээлийн асуудал*<br>НББОУС 19-д заасан удирдамжийн дагуу ажилчдын тэтгэмжийн бүртгэлд хэрэглэсэн хөнгөлөлтийн хувийг тодорхойлоход ашигласан өндөр чанартай корпорацийн бондыг тодорхойлсон бөгөөд түүнийг ажилчдад төлөх тэтгэмжүүдтэй ижил валютаар илэрхийлэгдсэн байх хэрэгтэй гэж шаарддаг.<br>Стандарт нь 2016 оны 01 сарын 01 ба түүнээс хойших хугацаанд заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |
| НББОУС 24, *Холбоотой талын тодруулга* | *Гол удирдах ажилтан*<br>Тус өөрчлөлтөөр тайлагнагч аж ахуйн нэгжид (эсвэл тайлагнагч аж ахуйн нэгжийн толгой компанид) гол удирдах ажилтны үйлчилгээ үзүүлдэг (‘удирдах аж ахуйн нэгж’) аж ахуйн нэгжийг тайлагнагч аж ахуйн нэгжийн холбоотой тал тодорхойлсон бөгөөд:<br>- удирдах аж ахуйн нэгжийн үзүүлсэн гол удирдах ажилтны үйлчилгээний зардлын дүнг тусад нь тодруулахыг шаардана<br>- НББОУС 24.17-д тусгасан ангиллын дагуу салгасан тодруулгыг хийхийг шаарддаггүй.<br>Стандарт нь 2014 оны 07 сарын 01 ба түүнээс хойших хугацаанд заавал хэрэгжүүлнэ. | Материаллаг нөлөөгүй |

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

### *(a) Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа*

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Тэмдэглэл 11-д өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааны талаар дэлгэрэнгүй тусгасан.

### *(b) Хойшлогдсон орлогын татварын хөрөнгө*

Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрийн эцэст шалгадаг бөгөөд үүнийг ирээдүйд хангалттай татварын өгөөж хүртэх боломжгүй болсон үед бүхлээр нь эсвэл хэсэгчлэн бууруулдаг. Үүнийг хэмжих магадлал нь хүлээгдэж буй ирээдүйн гүйцэтгэлд суурилан үнэлэгддэг. Хойшлогдсон татварын хөрөнгийн ирээдүйн ашиглалтын магадлалыг үнэлэхэд олон төрлийн хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Үүнд: Өмнөх үеийн үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөө, татварын стратеги төлөвлөлт болон цаашид шилжүүлэн тооцох татварын алдагдлын дуусгавар хугацаа зэрэг болно. Хэрвээ бодит үр дүн нь тооцоологдсон дүн эсвэл тооцооллоос өөр байвал энэ нь ирээдүйн үеүдэд санхүүгийн байдлын тайланд залруулагдах бөгөөд мөнгөн гүйлгээ болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө нь хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд шилжүүлэх үнэлгээ буурах бөгөөд энэхүү бууралтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

### *(c) Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт*

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээлийн мэдээлэл дээр үндэслэгдээгүй тохиолдолд, тэдгээрийн бодит үнэ цэнийг үнэлгээний загваруудыг хамарсан янз бүрийн үнэлгээний арга техникүүдийг ашиглан тодорхойлно. Боломжтой бол ажиглагдах зах зээл дээрээс эдгээр загваруудад ашиглах орцуудыг авч үнэлэх ба ийм боломжгүй тохиолдолд үнэлгээнд тооцоолол ашиглаж бодит үнэ цэнийг тодорхойлно. Энэ тооцоололд төлбөрийн чадвар болон үнэлгээний загварт орох орцуудтай холбоотой зээлийн эрсдэл, хамаарал болон хэлбэлзлийг харгалзан авч үзэх хэрэгтэй. Эдгээр хүчин зүйлүүдийн талаарх төсөөлөл дэх өөрчлөлт нь санхүүгийн байдлын тайланд тусгагдах санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тайлагнахад нөлөөлөх бөгөөд хэрэглүүрийн түвшин (level)-г бодит үнэ цэнийн шатлал гэсэн 12 хэсэгт тодруулсан. Үнэлгээний загварууд нь боломжтой тохиолдолд ижил төрлийн хэрэглүүр (өөрчлөлтгүйгээр) дэх тухайн үеийн зах зээл дээрх ажиглагдаж байгаа мэдээллээс авсан үнээр тестлэгдэж батлагдана.

### *(d) Хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Компани нь хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий бологч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг.
Бодит үнэ цэнэ нь тухайн арилжааны талаар зохих мэдлэг бүхий сонирхогч талуудын хооронд хөрөнгөө худалдах, өр төлбөр шилжүүлэгдэх эсвэл тохиролцсон үнээр тодорхойлогдоно.

## 4. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР – ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компани нь үйл ажиллагааны явцад дараах санхүүгийн эрсдэлүүдэд өртөх магадлалтай. Үүнд:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн бусад эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

Компани нь бусад бизнесүүдийн нэгэн адил санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсэх эрсдэлүүдтэй тулгардаг. Энэ тэмдэглэлд Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдэлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарлана. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллийг санхүүгийн тайланд зохих ёсоор тэмдэглэсэн.

Энэ тэмдэглэлд дурдаагүй бол компанийн өмнө тулгарсан санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл, түүнтэй холбоотой бодлого, эдгээр эрсдэлийг зохицуулах процесс эсвэл түүнийг хэмжихэд хэрэглэгдсэн аргуудад ямар нэгэн томоохон өөрчлөлт ороогүй болно.

2013 оны 12 сарын 31-ээр компанийн гол хувьцаа эзэмшигчид нь дараах байдалтай байна. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Нэрлэсэн үнэ | Нийт мян.төг | Хувь |
|---|---|---|---|---|
| Чулуун Ганхуяг | 2,128,610 | 100 | 212,861 | 15.47 |
| ЮуБиАйЖи ХХК | 1,468,449 | 100 | 146,845 | 10.67 |
| Аполло Вентурс | 1,290,000 | 100 | 129,000 | 9.37 |
| Мак ХХК | 873,000 | 100 | 87,300 | 6.34 |
| Луна Энд Луна ХХК | 763,068 | 100 | 76,307 | 5.54 |
| Лхагвасүрэн Соронзонболд | 711,450 | 100 | 71,145 | 5.17 |
| Мөнх-Очир Сэргэлэн | 586,710 | 100 | 58,671 | 4.26 |
| Баяртогтох Нэмэхбаатар | 507,834 | 100 | 50,783 | 3.69 |
| Сэдбазар Гэрэлтуяа | 450,000 | 100 | 45,000 | 3.27 |
| Галням Уянга | 402,561 | 100 | 40,256 | 2.93 |
| Дүгэрсүрэн Бат-Очир | 313,650 | 100 | 31,365 | 2.28 |
| Мягмарсүрэн Золжаргал | 300,000 | 100 | 30,000 | 2.18 |
| Магван Болд | 256,000 | 100 | 25,600 | 1.86 |
| Баянжаргал Дэлгэржаргал | 251,960 | 100 | 25,196 | 1.83 |
| Ронок Лимитед ХХК | 220,447 | 100 | 22,045 | 1.60 |
| **Гол хувьцаа эзэмшигчид** | **10,523,739** | 100 | **1,052,374** | **76.47** |
| Бусад 353 хувьцаа эзэмшигч | 3,238,438 | 100 | 323,844 | 23.53 |
| **Нийт хувьцаа** | **13,762,177** | 100 | **1,376,218** | **100.00** |

2014 оны 12 сарын 31-ээр компанийн гол хувьцаа эзэмшигчид нь дараах байдалтай байна. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Нэрлэсэн үнэ | Нийт мян.төг | Хувь |
|---|---|---|---|---|
| Интергрупп Интернэйшнл ХХК | 2,237,050 | 100 | 223,705 | 13.32 |
| UBIG ХХК | 1,907,059 | 100 | 190,706 | 11.35 |
| Apollo Ventures ХХК | 1,690,000 | 100 | 169,000 | 10.06 |
| VenturesOne BV | 1,304,043 | 100 | 130,404 | 7.76 |
| Чулуун Ганхуяг | 1,290,000 | 100 | 129,000 | 7.68 |
| Luna & Luna ХХК | 1,284,893 | 100 | 128,489 | 7.65 |
| МАК ХХК | 873,000 | 100 | 87,300 | 5.20 |
| Баяртогтох Нэмэхбаатар | 507,834 | 100 | 50,783 | 3.02 |
| Лхагвасүрэн Соронзонболд | 453,210 | 100 | 45,321 | 2.70 |
| Сэдбазар Гэрэлтуяа | 450,000 | 100 | 45,000 | 2.68 |
| Галням Уянга | 423,034 | 100 | 42,303 | 2.52 |
| Мөнх-Очир Сэргэлэн | 340,794 | 100 | 34,079 | 2.03 |
| Дүгэрсүрэн Бат-Очир | 313,650 | 100 | 31,365 | 1.87 |
| Хулдорж Бүрэн-Эрдэнэ | 306,000 | 100 | 30,600 | 1.82 |
| Мягмарсүрэн Золжаргал | 300,000 | 100 | 30,000 | 1.79 |
| **Гол хувьцаа эзэмшигчид** | **13,680,567** | **100** | **1,368,057** | **81.45** |
| Бусад 317 хувьцаа эзэмшигчид | 3,114,766 | 100 | 311,477 | 18.55 |
| Нийт хувьцаа эзэмшигчид | **16,795,333** | **100.00** | **1,679,533** | **100.00** |

## 22. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| **Тайлант үеийн эхэнд** | **3,246,555** | **3,303,839** | **2,700,450** |
| Нэмэгдэл (i) | 6,166,841 | 97,823 | 1,658,808 |
| Хасалт (ii) | (114,634) | (155,107) | (1,055,419) |
| **Тайлант үеийн эцэст** | **9,298,761** | **3,246,555** | **3,303,839** |

i. 2013 оны 12 сарын 27-ны өдрийн Ард Санхүүгийн Нэгдэл ХХК болон Интер Групп Интернэшнл ХХК -ийн хооронд байгуулсан гэрээний дагуу Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь Ард Даатгал ХХК -ийн нийт хувьцааны 33 хувийг Ард Санхүүгийн Нэгдэл ХХК -ийн 2,153,450 ширхэг хувьцаагаар солилцох гэрээ хийгдсэн болно. Мөн 2014 оны 12 сарын 31-ний өдрийн Ард Санхүүгийн Нэгдэл ХХК болон Ventures One B.V ХХК-тай байгуулсан хувьцаа солилцох гэрээний дагуу Ард Даатгал ХХК -ийн 333,000 мянган ширхэг хувьцааг Ард Санхүүгийн Нэгдлийн 1,304,043 ширхэг хувьцаагаар солилцсон болно. Тус хувьцаа нь солилцоотой холбоотой үүссэн нэмж төлөгдсөн капиталын дүнг илэрхийлнэ.

ii. Компани тайлант онд нийт 573,972 ширхэг хувьцааг халаасалсан бөгөөд хувьцаа халааслахтай холбоотой хувьцааны нэмж төлөгдсөн капитал нь хасагдах бичилт хийгдсэн.

## 23. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ТОХИРУУЛГЫН НӨӨЦ

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| **01 сарын 01-ний үлдэгдэл** | **5,291,986** | **3,500,408** | **-** |
| Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн тохируулга | 933,684 | 1,791,578 | 3,500,408 |
| **12 сарын 31-ний үлдэгдэл** | **6,225,670** | **5,291,986** | **3,500,408** |

## 24. ӨМЧИЙН БУСАД ХЭРЭГЛҮҮР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2007 оны 05 сарын 04-ний өдрийн №2007/06 тоот шийдвэрийн дагуу Хас Банкнаас хуваарилагдан ирсэн ногдол ашгийн 25 хувийг (14,299,079 төгрөг) нөөц байгуулсан. Мөн 2007 оны 05 сарын 21-ны өдрийн ТУЗ-ийн тушаалаар 500,000 төгрөгийг урамшуулал болгон хуваарилсан.

## 25. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

| | Голомт банк (Төгрөгөөр) мян.төг | Голомт банк (Ам.доллар) мян.төг | Төрийн банк* мян.төг | МАК мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **Үндсэн зээл** | | | | | |
| **2013 оны 1 сарын 1** | **620,000** | **741,943** | **275,978** | **1,989,055** | **3,626,976** |
| Эргэн төлөлт | (620,000) | (883,718) | (11,979) | - | **(1,515,697)** |
| Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг | - | - | (53,000) | (1,989,055) | **(2,042,055)** |
| Ханшийн зөрүү | - | 141,775 | - | - | **141,775** |
| **2013 оны 12 сарын 31** | **-** | **-** | **210,999** | **-** | **210,999** |
| Эргэн төлөлт | - | - | - | - | **-** |
| Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг | - | - | (210,999) | - | **(210,999)** |
| Ханшийн зөрүү | - | - | - | - | **-** |
| **2014 оны 12 сарын 31** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

## 25. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

* 2012 оны 05 сарын 14-ний өдөр Ард Санхүүгийн Нэгдэл ХХК болон Төрийн банкны хооронд байгуулсан №197 тоот зээлийн гэрээгээр 280 сая төгрөгийн зээлийг жилийн 20.4 хувийн хүүтэйгээр 36 сарын хугацаатайгаар санхүүгийн үйлчилгээний туслах үйл ажиллагааны зориулалтаар авсан. Энэхүү зээлийн барьцаанд Сүхбаатар Дүүрэг 8-р хороо, бага тойруу /14200/, Б.Алтангэрэлийн гудамж 5-403 тоотод орших 170.44 м.кв талбай бүхий Ү-2203023321 гэрчилгээний дугаартай конторын барилгыг 411,318,170 төгрөгийн үнэлгээтэйгээр барьцаалсан.

## 26. УРТ ХУГАЦААТ САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ӨГЛӨГ

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| Санхүүгийн түрээсийн өглөг | **-** | **24,990** | **24,990** |
| *Үүнд:* | | | |
| Урт хугацаат түрээсийн тайлант жилд төлөгдөх хэсэг | - | 24,793 | 12,396 |
| Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг | - | 199 | 12,594 |

## 27. ХУДАЛДААНЫ БА БУСАД ӨГЛӨГ

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 1 сарын 1 мян.төг |
|---|---|---|---|
| Аж ахуй нэгжид өгөх өглөг | 523,345 | 841,215 | 131,753 |
| Хувь хүнд өгөх өглөг | - | 1,565,790 | 544,896 |
| Ажилчдад өгөх өглөг | - | 96 | 12 |
| Цалингийн өглөг | 2,083 | - | 68 |
| Хойшлогдсон орлого | 15,000 | - | 119,205 |
| Хувьцааны өглөг | 216,400 | 5 | 161,106 |
| Зээлийн хүүгийн өглөг | 708 | - | 9,505 |
| Бусад өглөг | 32,193 | 1,554 | - |
| ХХОАТ өглөг | - | - | 4 |
| НӨАТ өглөг | - | 39,979 | - |
| Үл хөдлөх хөрөнгийн өглөг | - | 1,255 | - |
| Суутган татварын өглөг | 1,211 | - | 458 |
| | **790,940** | **2,449,893** | **967,007** |

## 28. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨР

Энэхүү дүн нь бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн залруулгаас үүссэн түр зөрүүний дүнд бий болсон хойшлогдсон татварын өр төлбөрийн дүнг илэрхийлнэ.

| | 2014 оны 12 сарын 31 | 2013 оны 12 сарын 31 | 2013 оны 1 сарын 1 |
|---|---|---|---|
| | мян.төг | мян.төг | мян.төг |
| **Тайлант оны эхэнд** | **5,646,944** | **1,568,981** | **1,079,617** |
| Тайлант онд хэрэгжсэн хэсэг | (1,186,490) | - | - |
| Тайлант жилд үүссэн | 210,550 | 4,077,963 | 489,364 |
| **Тайлант оны эцэст** | **4,671,006** | **5,646,944** | **1,568,981** |

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

### 29.1 Орлого

Эдийн засгийн өгөөжийг Компани хүртэх магадлалтай байх болон орлогыг найдвартай байдлаар хэмжиж болохуйц бол орлогыг хүлээн зөвшөөрдөг.

- ***Шимтгэлийн орлого***

Компанийн үндсэн үйл ажиллагааны орлого нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ болон диллер, брокер болон андеррайтингийн үйлчилгээ болно. Орлогыг НББОУС-ын дагуу аккруэл суурийг ашиглан бүртгэдэг.

- ***Хүүгийн орлого***

Хүүгийн орлогыг үндсэн зээл буюу хэрэглүүрийн үлдэгдэл болон холбогдох харилцах хадгаламжийн үлдэгдэл болон үр ашигт хүүгийн түвшнээр тооцож, аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө.

- ***Түрээсийн орлого***

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого нь холбогдох түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

### 29.2 Өртөг / Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

### 29.3 Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого болон охин компани, бусад холбоотой бус талуудад олгосон зээлийн хүүгийн орлого, богино хугацаат бондын хүүгийн орлого зэргийг хамруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардлыг хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

### 29.4 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Төгрөгөөс өөр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг албан ёсны ханш руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшийг ашиглан хөрвүүлэгдсэн ба гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зардлуудын ажил гүйлгээнүүд нь гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлэгдсэн болно. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн бүх ханшийн зөрүүний олз ба гарзыг орлого үр дүнгийн тайланд тусгана.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.4 Гадаад валютаарх ажил гүйлгээ (үргэлжлэл)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүд нь түүхэн өртгөөр илэрхийлэгдэж төгрөг рүү хөрвүүлэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшийг ашигладаг.

### 29.5 Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй. Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

### 29.6 Ажилчдын тэтгэмж

#### i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

#### ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.7 Санхүүгийн хэрэглүүрүүд

(i) ***Ангилал***

Компани нь өөрийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө НББОУС 39,*Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт* дагуу доорх ангиллын ашиглан хүлээн зөвшөөрдөг.

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь доорх дэд ангиллуудад хуваагдана. Үүнд:

- *Борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө өр төлбөр: Ойрын* хугацаанд дахин худалдаалах болон эсвэл арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгүүд нь энэ ангилалд хамаарна. Энэ ангилалд өмчийн, өрийн болон бусад хүү бүхий санхүүгийн хөрөнгө оруулалтууд болон эсвэл үүсмэл санхүүгийн хэрэгслүүд багтдаг. Эдгээр хөрөнгүүд нь ерөнхийдөө үнийн богино хугацааны хэлбэлзлээс ашиг хүртэх зорилготой байдаг. Бүх богино хугацаанд худалдан борлуулах зорилготой үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд, өрийн санхүүгийн хэрэглүүрүүд нь борлуулах зорилготой гэсэн ангилалд хамрагдана.

- *Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт:* Эдгээр ангилалд охин компани болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтуудыг хамруулна. Эдгээр хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө компанийн хөрөнгө оруулалтын стратеги ба эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу бүлэг санхүүгийн хэрэглүүрийн нэгэн хэсэг болгон удирдаж, тэдгээрийн гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлнэ.

- *Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт*: СТОУС 10 буюу *Нэгтгэсэн санхүүгийн тайланд* тусгаснаар Компани нь охин компаниудыг санхүүгийн тайландаа нэгтгэхгүй. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтууд нь бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хэрэглүүрээр бүртгэгдэнэ.

- *Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтууд*: НББОУС 28 буюу *Хараат болон Хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт хэмээх стандартад* тусгаснаар Компани хараат компани дах хөрөнгө оруулалтаа өмчийн арга ашиглан бүртгэхгүй. Үүний оронд Компани нь бодит үнэ цэнийг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх аргыг сонгож хэмждэг.

***Зээл болон авлага***

Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй тодорхойлж болохуйц эсвэл тогтмол төлбөртэй үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Энэхүү ангилалд бусад богино хугацаат авлагууд болон репо хэлцэл худалдан авах нөөц, зээлээрх үнэт цаасны мөнгөн барьцаа зэргийг хамруулдаг.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.7 Санхүүгийн хэрэглүүрүүд (үргэлжлэл)

***Бусад санхүүгийн өр төлбөрүүд***

Энэ ангилалд дуусгавар хугацааны эцэст борлуулах зорилготой өр төлбөрийн ангилалд хамрагдсан өр төлбөрүүдээс бусад санхүүгийн өр төлбөрүүдийг хамруулна. Бусад богино хугацаат өглөг болон репо хэлцэл, үнэт цаасны мөнгөн барьцаа зэргийг хамруулдаг.

(ii) ***Хүлээн зөвшөөрөлт***

Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийг гэрээт үүргийн нэг тал болох үед санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрдөг.

Зах зээл дээрх тохирсон гэрээ эсвэл дүрмийн дагуух хугацаанд санхүүгийн хөрөнгийн ердийн худалдан авалт болон борлуулалтыг тухайн хөрөнгийг худалдах эсвэл борлуулахаар үүрэг хүлээсэн худалдааны өдрийг ашиглан бүртгэдэг.

(iii) ***Анхны хэмжилт***

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Эдгээр хэрэглүүрүүдтэй холбоотой бүх ажил гүйлгээний өртгүүд нь шууд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгддөг.

Бусад санхүүгийн хэрэглүүрт харьяалагдах агуулагдсан үүсмэл хэрэглүүр нь тусдаа үүсмэл хэрэглүүрээр бүртгэгддэг бөгөөд хэрвээ эдгээрийн эдийн засгийн шинж чанар болон эрсдэл нь үндсэн гэрээтэй холбоогүй бол бодит үнэ цэнээр бүртгэнэ. Үндсэн гэрээ нь борлуулах зорилготой хөрөнгөөр ангилагдахгүй эсвэл бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.Үндсэн гэрээндээ бодит үнэ цэнээр бүртгэгдсэн агуулагдсан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэгдэнэ.

Авлага болон зээлүүд мөн санхүүгийн өр төлбөрүүд нь (борлуулахад бэлэн гэсэн ангилалд хамрагдсанаас бусад) анх хэмжихдээ бодит үнэ цэнэ дээр нь санхүүгийн хөрөнгийг олж эзэмших, гаргахтай шууд холбоотой гарсан гүйлгээний өртгийг нэмсэн дүн байна.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхөд бодит үнэ цэнэ нь бүртгэгдсэн ажил гүйлгээний үнэтэй тэнцүү бус байвал Компани нь эдгээрийн зөрүүг энд тусгайлан заагаагүй бол дэлгэрэнгүй орлогын тайлан дахь өөрчлөлт нь нөөцөөр хүлээн зөвшөөрнө.

(iv) ***Дараа үеийн хүлээн зөвшөөрөлт***

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа Компани нь бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх хэрэгсэлд ангилагдсан санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Эдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнэд дараа үеүдэд орсон өөрчлөлтүүд нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн цэвэр олз эсвэл гарзаар тайлагнана. Эдгээрт хэрэглүүрт төлж байгаа хүү эсвэл хүлээн авсан ногдол ашиг зэрэг нь хүүгийн орлого эсвэл зардал болон ногдол ашгийн зардал эсвэл орлого гэсэн дансанд тусдаа бүртгэгдэнэ.
Зээл болон авлага нь үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.7 Санхүүгийн хэрэглүүрүүд (үргэжлэл)

(iv) ***Дараа үеийн хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)***

Авлага болон зээлийг үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, мөн хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз эсвэл гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.
Бодит үнэ цэнэ ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх хэсэгт ангилснаас бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг.

Өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх мөн хорогдуулгын хөтөлбөрийн үед үүсэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцдог ба тухайн хамаарах хугацаанд хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлаар хуваарилдаг арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөрүүд эсвэл хүлээн авах дүнгүүдийг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаанд нь эсвэл санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны цэвэр дүн хүртэлх богино хугацаанд нь яг зөв дүнгээр хорогдуулж буй түвшинг хэлнэ. Компани нь үр ашигт хүүгийн түвшин тооцохдоо санхүүгийн хэрэгслүүдийн бүх гэрээт нөхцөлүүдийг хамарсан мөнгөн урсгалыг тооцоолох ба ирээдүйн алдагдлыг харгалзан үзэхгүй. Тооцоололд гэрээний талуудын хооронд үр ашигт хүүгийн түвшин, ажил гүйлгээний өртөг, бусад бүх урамшуулал, хөнгөлөлттэй салшгүй холбоотой төлсөн эсвэл хүлээн авсан бүх төлбөрүүд багтана.

(v) ***Үл хүлээн зөвшөөрөх***

Санхүүгийн хөрөнгөөс (ижил төрлийн бүлэг санхүүгийн хөрөнгийн нэг хэсэг эсвэл санхүүгийн хөрөнгийн нэг хэсэг) хүлээн авдаг мөнгөн урсгалын эрхийн хугацаа дуусгавар болсон, компани хөрөнгөөс мөнгөн хүлээн авах эрхээ шилжүүлсэн, уг эрх байгаа боловч тэдгээрийг хугацаа алдалгүйгээр гуравдагч талд бүхэлд нь төлөх үүргийг хүлээж байгаа бол мөн дараах тохиолдлуудад үл хүлээн зөвшөөрнө:

- Компани нь хөрөнгийн бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлсэн ; эсвэл
- Компани нь хөрөнгийн эрсдэл, өгөөжийг бүхэлд нь шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтаа шилжүүлсэн бол.

Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн буюу дамжуулах хэлцэлд оролцож байх үед болон тухайн хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй буюу хадгалж үлдээгүй боловч хяналтаа алдаагүй үед, санхүүгийн байнгын оролцооны хэмжээтэй нь уялдуулан энэхүү хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн байна. Энэ тохиолдолд Компани нь холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрдөг. Компанид хэвээр үлдсэн эрх ба үүргийг тусгахуйц суурийн дагуу шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг хэмжинэ. Компани нь санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.8 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь өмч, охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, мөн түүнчлэн өмчийн, өрийн болон бусад хүү бүхий хөрөнгө оруулалт, үүсмэл хэрэглүүрүүдэд оруулсан санхүүгийн хэрэглүүрүүдийг тайлант хугацааны эцэс бүрд бодит үнэ цэнээр хэмждэг.

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийж буй өдрөөрх зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгийг худалдах буюу өр төлбөрт шилжүүлэн тооцох байнгын ажил гүйлгээ хийгдэх үнэ юм.

Бодит үнэ цэнийн хэмжилт нь үндсэн зах зээл дээрх хөрөнгө, өр төлбөр эсвэл үндсэн зах зээл байхгүй бол хамгийн их давуу тал бүхий зах зээл дээрх аль ч хөрөнгө өр төлбөрийн хувьд хөрөнгийг худалдах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх ажил гүйлгээ гэсэн таамаглалд тулгуурладаг. Үндсэн зах зээл болон хамгийн их давуу тал бүхий зах зээлд Компани нь нэвтрэх боломжтой байх ёстой.

Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо хийдэг таамаглалыг ашиглан аж ахуй нэгж нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжих бөгөөд ингэхдээ зах зээлд оролцогчид нь эдийн засгийн ашиг сонирхлоо хамгийн өндөр түвшинд хангах үүднээс зах зээлд оролцоно гэсэн таамаглалыг үндэс суурь болгоно.

Санхүүгийн тайлангийн өдрөөр идэвхтэй зах зээл дээр худалдаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь ямар нэгэн ажил гүйлгээний зардлыг хасалгүйгээр тэдгээрийн жишиг үнэ буюу диллерийн арилжааны үнэ (Урт позицид нээлттэй үнэ болон богино позицид тохиролцох үнэ) байна. Бирж дээр бүртгэгдсэн үнэт цааснууд нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаг.

Хэрвээ компанид зах зээлийн эрсдэл ба түншийн зээлийн эрсдэлийг нэгтгэж цэвэршүүлэх нөхцөл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөр байгаа бол СТОУС-т зааснаар Бид болон Аск үнэнд үндэслэн цэвэр эрсдэлийн үнийг тогтооно.

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй бусад бүх санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнэ нь тухайн нөхцөл байдалд тохирсон үнэлгээний аргуудыг ашиглан тооцоологддог. Үнэлгээний аргуудад зах зээлийн хандлага (тухайлбал,ижил төстэй өөр нэгэн санхүүгийн хэрэглүүрийн хамгийн сүүлчийн зах зээлийн үнэ буюу жишиг үнийг ашиглах ) орлогын хандлага (зах зээлийн хангалттай бөгөөд боломжит мэдээлэлд тулгуурласан опционы үнэлгээний загварууд болон мөнгөн урсгалыг дискаунтчилах арга) байна.

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд нь санхүүгийн тайланд тодруулагдах эсвэл хэмжигдэхдээ бодит үнэ цэнийн шатлал(hierarchy)-аар ангилагддаг бөгөөд доор тайлбарласнаар орцын хамгийн доод түвшинд үндэслэгддэг үүнд:

- Түвшин 1- Тодорхой хөрөнгө, өр төлбөрүүдийн хувьд идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаг зах зээлийн жишиг үнэ (тохируулагдахгүй)
- Түвшин 2- Үнэлгээний аргууд нь бодит үнэ цэнийг хэмжихдээ шууд ба шууд бусаар олж авах боломжтой ажиглагдах хамгийн бага түвшний орцыг ашигладаг. (тохируулсан үнэ)
- Түвшин 3- Бодит үнэ цэнийг тодорхойлоход үл ажиглагдах орцын мэдээлэл ашигласан үнэлгээний аргууд (Жишээ нь Мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох)

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.9 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнэ нь буурсан гэсэн биет нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд Компани нь эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

Хэрэв нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах хүү байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна.
Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг орлогын тайлан болон бусад харьцуулсан орлогын тайланд санхүүгийн орлогоор бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна.

Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл орлогын тайлангийн санхүүгийн зардал дансны кредитэд бүртгэнэ. Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах хүү байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.10 Өмч, барилга, тоног төхөөрөмж

***i) Үндсэн хөрөнгийг ангилах***

Нэгээс дээш тайлант жилд ашиглагдах, ашиглалтын боломж хугацаа нь хязгаарлагдмал, бизнесийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах, дахин худалдах зориулалтгүй, үйлдвэрлэл үйлчилгээний болон түрээслүүлэх, захиргааны зориулалтаар ашиглагдан элэгдлийн үндсэн дээр анхны өртгөө зардалд шингээх хөрөнгүүдийг эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна.

***ii) Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт***

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Анхны өртөг нь худалдан авсан үнэ, худалдан авах болон олж бэлтгэх, ашиглахад бэлэн болгохтой холбогдон нэмж гарах шууд зардлуудаас бүрдэнэ. Энэ нэмэгдэл зардалд ачиж буулгах, тээвэрлэх, суурилуулах болон төлсөн гаалийн хураамж орно.

Гадаад валютаар худалдан авсан хөрөнгийн өртгийг тодорхойлохдоо худалдан авалт хийгдсэн өдрийн Монгол банкны албан ханшаар үржүүлж өртөгт шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах ба худалдах үед холбогдох олз ба гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

***iii) Дараа үеийн хэмжилт***

Үндсэн хөрөнгийг ашиглах явцад түүнийг сайжруулах, засварлахтай холбогдон гарах зардлууд нь дараах нөхцөлийг хангаж байвал үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж капиталжуулна.

- Хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгаж байвал
- Хүчин чадлыг нэмэгдүүлж байвал
- Хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж байвал

***iv) Элэгдэл***

Элэгдлийг үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд тусгана. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох эдийн засгийн ашиглалтын хугацаа нь Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуульд заасан хугацаанаас материаллаг зөрүүгүй байдаг учраас татварын хуульд заасан хугацааг элэгдүүлэх хугацаа хэмээн сонгож авсан. Тогтоосон ашиглагдах хугацаа дараах байдалтай байна.

| | |
|---|---|
| ▪ Компьютер түүний эд анги, программ хангамж, цахилгаан бараа | 3 жил |
| ▪ Конторын тавилга, эд хогшил | 10 жил |

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.11 Бараа материал

Бараа материал нь бичиг хэргийн материал, аж ахуйн материал гэсэн хангамжийн зүйлээс бүрдэнэ. Бараа материалыг байнгын системээр бүртгэнэ

### 29.12 Худалдааны болон бусад авлага

Худалдааны авлагыг эхлээд бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрдөг бөгөөд дараа нь худалдааны авлагын үнэгүйдлийг хассан хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Худалдааны авлагын үнэгүйдлийн хасагдуулга нь компани авлагын анх үүссэн үеийн нөхцөлийн дагуу бүрэн хэмжээгээр цуглуулж чадахгүй байж магадгүй гэсэн бодит нотолгоонд суурилан тогтоодог. Хасагдуулгын дүн нь дансны үнэ ба таамагласан мөнгөн урсгалыг ижил төрлийн зээл борлуулалтын зах зээлийн хүүгийн түвшингээр хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээр тогтоосон эргэн нөхөгдөх дүнгийн хоорондын зөрүү юм. Хасагдуулгын дүнг орлогын тайлан ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютаарх авлагын дансны үнийг тайлангийн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж тодорхойлно. Тайлант хугацааны дундуур гадаад валютаар төлсөн авлагыг төгрөгт шилжүүлж ханшийн зөрүүгийн бодит олз ба гарзыг тооцно.

### 29.13 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

### 29.14 Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

### 29.15 Өөрийн хөрөнгө

***i) Хувьцаат капитал***

Гаргасан бүх хувьцаа нь энгийн хувьцаа бөгөөд өмчөөр ангилсан. Шинээр хувьцаа эсвэл опцион гаргахад холбогдох нэмэгдэл өртгөөс нь ногдуулсан аливаа татварыг нь хассан цэвэр дүнгээр өмчид тайлагнана.

Хувьцаат капитал нь энгийн хувьцааг хувьцааны нэрлэсэн үнээр үржүүлсэн дүнг илэрхийлнэ.

***ii) Халаасны хувьцаа***

Буцаан олж эзэмшиж буй өөрийн өмчийн хэрэглүүрүүд (халаасны хувьцаа) нь өмчөөс хасагдах бөгөөд тухайн үед тус ажил гүйлгээтэй холбоотой нэмэлт зардлуудыг агуулсан төлсөн төлбөрийн дүнгээр бүртгэнэ. Нөөцийн бодлого нь хувьцааг халааслах замаар хадгалах бус буцаан худалдан авсан хувьцааг цуцлах байдаг.

Нөөцийн өмчийн санхүүгийн хэрэглүүрүүдийг цуцлах, гаргах, худалдах, худалдаж авахад үүссэн ямар ч олз, гарзууд нь бусад харьцуулсан орлогын тайланд бүртгэгдэхгүй.

## 29. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

### 29.16 Нөөц/Сан

Компани нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг байгаа болон энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөц/санг хүлээн зөвшөөрнө.

### 29.17 Бодит үнэ цэнийн нөөц

Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд нь санхүүгийн байдлын тайлангийн өмчийн хэсэгт бодит үнэ цэнийн нөөцөөр бүртгэгдсэн.

### 29.18 Ногдол ашиг

Ногдол ашгийг түүнийг зарласан тайлангийн хугацаанд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

## 30. ХОЛБООТОЙ ТАЛ

### *Холбоотой талуудыг тодорхойлох нь*

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.
Тус компани нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:

i. Компанийн захирлууд болон гүйцэтгэх удирдлагууд
ii. Хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн бусад компани;

Хувь нийлүүлэгчийн эзэмшлийн дараах компаниудтай холбоотой талын харилцаатай байдаг. Үүнд:

| Холбоотой талуудын нэр | Бизнесийн үйл ажиллагаа | Холбоо хамаарал |
|---|---|---|
| Ард Даатгал ХХК | Даатгал | Хараат компани |
| Номын Хишиг ХХК | Хэвлэл | Хяналтын бус хувь оролцоо |
| Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК | Санхүү ба хөрөнгө оруулалт | Хяналтын бус хувь оролцоо |
| Ард Кредит ББСБ | ББСБ | Хамтарсан үйлдвэр |
| Техник Технологийн Дээд Сургууль ХХК | Боловсрол | Хамтарсан үйлдвэр |
| И Ай Ти Капитал Менежмент ХХК | Хөрөнгө оруулалт | Хараат компани |
| МТНД ХХК | Бизнесийн зөвлөх | Охин компани |
| Ард Актив ХЗХ | Хадгаламж зээлийн хоршоо | Охин компани |
| Арвай Капитал ХХК | Бизнесийн зөвлөх | Охин компани |
| Тэнгэр Системс ХХК | Программ хангамж | Охин компани |
| Монет Капитал УЦК | Брокер, дилер | Охин компани |
| Вайлд Дижитал ХХК | Веб дизайн | |
| Ч.Ганхуяг | N/a | Гүйцэтгэх захирал |
| А.Батболд | N/a | ТУЗ-ийн гишүүн |
| С.Гэрэлтуяа | N/a | Хувьцаа эзэмшигч |

Холбоотой талуудтай хийсэн томоохон ажил гүйлгээний дүн доорхи байдлаар илэрхийлэгдэнэ:

| | 2014 он мян.төг | 2013 он мян.төг |
|---|---:|---:|
| Олгосон зээл | 321,533 | 532,525 |
| Зээлийн эргэн төлөлт | (316,118) | (287,006) |
| Үзүүлсэн үйлчилгээний орлого | 107,759 | 609,091 |
| Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал * | 249,773 | 167,888 |
| | **362,947** | **1,022,497** |

## 30. ХОЛБООТОЙ ТАЛ (үргэлжлэл)

Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал:

| | 2014 он мян.төг | 2013 он мян.төг |
|---|---|---|
| Цалингийн зардал | 223,394 | 151,124 |
| Нийгмийн даатгалын зардал | 24,752 | 16,764 |
| Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөөний зардал | 1,627 | - |
| | **249,773** | **167,888** |

Холбоотой талуудаас авах авлага болон өглөгүүд нь доорх байдалтай байна.

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Ард Кредит ББСБ | 516,901 | 535,947 |
| Тэнгэр системс ХХК | 4,976 | - |
| ТТДС ХХК | 1,000 | - |
| МТНД ХХК | (506,987) | (529,815) |
| Ард Актив ХЗХ | (15,907) | - |
| Монет ҮЦК ХК | (15,000) | - |
| Номын хишиг ХХК | 11,620 | - |
| Хувь нийлүүлэгчид | 120,510 | (264,271) |
| **Нийт** | **117,114** | **(258,139)** |

Холбоотой талд оруулсан богино хугацаат бондоорх хөрөнгө оруулалт нь доорх байдалтай байна.

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Ард Кредит ББСБ | 150,000 | - |
| **Нийт** | **150,000** | **-** |

## 31. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2015 оны 01 сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Жинст Увс ХК -ийн нийт гаргасан хувьцааны 84 хувийг 54 сая төгрөгөөр худалдан авах шийдвэр гаргасан.

## 32. ЗЭРЭГЦҮҮЛСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант жилийн эдгээр санхүүгийн тайлантай нийцүүлэх үүднээс зэрэгцүүлэх боломжгүйгээс бусад тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

## 33. АНГЛИ ОРЧУУЛГА

Санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэлнээ үйлдэгдсэн бөгөөд Англи хэл болон Монгол хэл дээрх хувилбаруудад орчуулгын ямар нэгэн ялгаа гарвал Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.